



Нийлүүлэгчдэд зориулсан олон улсад мөрдөгдөх бизнесийн ёс зүйн дүрэм

АВЛАГА НЬ 2026 ОНЫ БАЙДЛААР ХҮЧИНТЭЙ БАЙГАА
БОЛНО.

Amway



Оршил

Alticor Inc. нь түүний шууд болон шууд бус толгой компаниуд, охин компаниуд, олон салбар нэгжүүд болон Amway компанийг багтаадаг бөгөөд АНУ-ын Мичиган мужийн Ада хотод төвтэй, эрүүл мэнд болон чанартай амьдралд чиглэсэн, Бизнес эрхлэгч төвтэй удирдлагын загвартай дэлхийн хэмжээний компани юм.

Бидний үйл ажиллагаа явагдаж байгаа 100 гаруй улс орон, нутаг дэвсгэрт манай бизнестэй холбогдсон хүн бүрт **бид илүү сайн сайхан амьдрахад нь туслах** алсын хараагаа баримтлан тууштай хэвээр байгаа. Бид үүнийг Amway Бизнес Эрхлэгчид (АБЭ), хэрэглэгчид, ажилчид, мөн нийлүүлэгчид болон түншүүдтэйгээ тогтоосон харилцаагаараа дамжуулан хэрэгжүүлдэг. Amway-ийн үнэт зүйлс нь бидний ажлыг чиглүүлж, итгэлцлийг бэхжүүлэн, бизнесийг ёс зүйтэй эрхлэх зарчмуудыг хангахад тусалдаг.

- **Түншлэл** — бид бие биедээ итгэж, харилцан хүндэтгэж, хамтын амжилтад хүрэхэд шаардлагатай харилцан нөхөх ур чадваруудыг үнэлдэг.
- **Хувь хүний үнэт зүйлс** — бид хүн бүхнийг дээдлэн, хүндэтгэдэг бөгөөд өөрийн чадвар чадамжаа бүрэн дүүрэн хэрэгжүүлэх боломжийг бид хүн болгонд өгөхийг эрмэлздэг.
- **Хариуцлага** — бид өөрийнхөө өмнө, бие биенийхээ өмнө болон үйлчилж буй нийгэмлэг, хамт олныхоо өмнө хийж буй үйлдэл, хүрч буй үр дүнгийнхээ төлөө үргэлж хариуцлага үүрдэг.
- **Шударга байдал** — бид үг болон үйлдэлдээ үнэнч, зоригтой, тууштай байдаг.

Эдгээр үнэт зүйлс нь хариуцлагатай худалдан авалт хийх, байгаль орчны тогтвортой байдлыг хангах, нийгэмд эерэг нөлөө үзүүлэх, мөн дэлхий өнцөг бүрт манай ханган нийлүүлэлтийн сүлжээнд ажиллаж буй хүмүүсийн аюулгүй байдал, тав тух хангаж байгаа зэргээр илэрдэг.

Энэхүү Нийлүүлэгчдэд зориулсан олон улсад мөрдөгдөх бизнесийн ёс зүйн дүрэм нь (Нийлүүлэгчдэд зориулсан бизнесийн Ёс зүйн дүрэм эсвэл Дүрэм) нийлүүлэгчдэд дараах чиглэлүүдийн дагуу дагаж мөрдвөл зохих стандартуудыг (Стандарт) тогтоодог:

- Шударга байдал ба бизнесийн ёс зүй
- Хүний эрх ба хөдөлмөрийн харилцаа
- Хөдөлмөр хамгаалал, ажлын байрны аюулгүй байдал
- Байгаль орчны хамгаалал
- Хариуцлагатай эх үүсвэрээс нийлүүлсэн материалууд

Энэхүү Дүрэм нь Amway компанид бүтээгдэхүүн нийлүүлдэг эсвэл үйлчилгээ үзүүлдэг дэлхий даяарх бүх нийлүүлэгчид (Нийлүүлэгч(үүд))-тэй харилцах харилцааны үндэс суурь болно. Энэхүү Дүрэм нь итгэлцэл, ил тод байдал, харилцан хүндлэл дээр суурилсан. Нийлүүлэгчид маань үйл ажиллагаандаа болон ханган нийлүүлэх сүлжээндээ эдгээр Стандартуудыг баримтлахаас гадна ажилчид, нийлүүлэгчид, худалдагчид, агентуудаар, гэрээт болон туслан гүйцэтгэгчдээрээ, мөн өөрсдийн объектууд дээр дагаж мөрдүүлнэ гэж бид найдаж байна.

Шударга байдал ба бизнесийн ёс зүй

Amway компани үйл ажиллагаагаа явуулж буй улс орнууддаа бизнесийн ёс зүйн хамгийн өндөр стандартуудыг баримтлан, хууль тогтоомж, норм хэм хэмжээний актуудын шаардлагыг дагаж мөрдөхийг эрмэлздэг. Бид байгаль орчны болон хөдөлмөр хамгаалал, аюулгүй байдлын одоо ашиглагдаж буй хууль тогтоомж, эрх зүйн актууд, корпорацийн стандартууд, түүнчлэн бидний дэмждэг бусад стандартуудын шаардлагуудыг хангах эсвэл түүнээс илүү гарахыг хичээдэг. Нийлүүлэгчдээсээ яг ийм хандлагыг хүлээдэг.

Хэрэв энэхүү Дүрмийн аль нэг заалт нь одоо хүчин төгөлдөр мөрдөгдөж буй хууль тогтоомжтой зөрчилдвөл Нийлүүлэгчид хууль эрх зүйн шаардлагуудыг биелүүлэнгээ уг Дүрмийн үндсэн зарчмуудыг баримтлах тал дээр хүчин чармайлт гаргах ёстой. Хэрэв энэхүү Дүрэм нь хууль тогтоомж эсвэл зохицуулалтаар шаардсанаас илүү өндөр стандартыг тогтоосон бол Нийлүүлэгчид илүү өндөр стандартыг нь дагаж мөрдөх ёстой.

АВЛИГА, ХЭЭЛ ХАХУУЛИЙН ЭСРЭГ АРГА ХЭМЖЭЭНҮҮД

Бид бүх төрлийн хээл хахууль, авлигыг үл тэвчих бодлогыг баримталдаг. Нийлүүлэгчид хээл хахууль, авлигын эсрэг холбогдох бүх хуулиудыг чанд даган мөрдөх үүрэгтэй. Нийлүүлэгчид Amway-н ажилчид, үйлчлүүлэгчид, төрийн албан хаагчид, улс төрийн намууд, төрийн албанд нэр дэвшигчид болон бусад хүмүүст хууль бусаар мөнгө төгрөг, бэлэг болон бусад үнэ цэнэтэй зүйлийг санал болгож өгөхийг эрс хориглоно. Энэхүү шаардлагад визний эсвэл гаалийн бүрдүүлэлт зэрэг төрийн байгууллагуудын ердийн үйл ажиллагааг хурдасгах, хөнгөвчлөхөд чиглэгдсэн төлбөрүүд бас багтах бөгөөд эдгээр төлбөрийг тухайн орон нутгийн хуулиар хориглоогүй байсан ч үүнд адилхан хамаарна.

МОНОПОЛЫН ЭСРЭГ ХУУЛЬ БА ШУДАРГА ӨРСӨЛДӨӨН

Нийлүүлэгчид монополийн эсрэг болон шударга өрсөлдөөний холбогдох бүх хуулиудыг дагаж мөрдөх үүрэгтэй. Нийлүүлэгчид нь үнэ тогтоох, зах зээлийг хуваах, үйлдвэрлэлийн хүчин чадлыг хязгаарлах эсвэл тендерийн журмыг хэлэлцэх зэргээр өрсөлдөөнт процессуудын шударга байдлыг алдагдуулах зорилготой аливаа гэрээ хэлэлцээг өрсөлдөгч талуудтай явуулахыг хатуу хориглоно.

АШИГ СОНИРХОЛЫН ЗӨРЧИЛДӨӨН

Нийлүүлэгчид бизнесийн ёс зүйн хамгийн өндөр стандартуудыг дагаж мөрдөх шаардлагатай бөгөөд ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээнүүдийг авч, Amway-тэй хамтран ажиллах явцад ийм зөрчил үүссэн тохиолдолд энэ талаар заавал мэдээлэх ёстой.

Ашиг сонирхлын зөрчилдөөн гэдэгт Нийлүүлэгчийн хувийн ашиг сонирхол эсвэл түүний ойрын хамаатан садан, найз нөхөд, салбар байгууллагуудынх нь ашиг сонирхол Amway-н ашиг сонирхолтой зөрчилдөж болзошгүй аливаа нөхцөл байдал, мөн Нийлүүлэгч нь Amway-тэй өрсөлдөж болохуйц бизнест өмчийн ашиг сонирхолтой байх тохиолдлууд зэрэг нь багтана.

НУУЦЛАЛ, ӨГӨГДӨЛ ХАМГААЛАЛТ БОЛОН МЭДЭЭЛЛИЙН АЮУЛГҮЙ БАЙДАЛ

Amway компани хувийн нууцлалын эрхийг хүний суурь эрхийн нэг гэж үздэг. Нийлүүлэгчид нь Amway-ээс, Amway-н нэрийн өмнөөс эсвэл Amway-н ажилчид, хэрэглэгчид, үйлчлүүлэгчид, зочид, ханган нийлүүлэгчид, Amway-н бие даасан бизнес эрхлэгчид (ABO/IBO) болон бизнесийн бусад түншүүдээс авсан хувийн мэдээллийг цуглуулах, хадгалах, ашиглах эсвэл өөр зорилгоор боловсруулахдаа нууцлал болон өгөгдөл мэдээлэл хамгаалахтай холбоотой одоо хүчин төгөлдөр мөрдөгдөж буй хуулиудыг дагаж мөрдөх үүрэгтэй. Нийлүүлэгчид мэдээллийн аюулгүй байдлыг өндөр түвшинд хангахын зэрэгцээ Amway-ээс дамжуулсан бүх өгөгдөл мэдээллийг хамгаалахын тулд зохих техникийн болон зохион байгуулалтын арга хэмжээнүүдийг авах ёстой. Эдгээр үүрэг нь мэдээлэл хадгалах хэлбэрээс (цахим, биет эсвэл аман) үл хамааран хэрэгжих бөгөөд мэдээлэл боловсруулах, хадгалах, дамжуулах гээд бүхий л үе шатуудад хамаатай болно.

ОЮУНЫ ӨМЧИЙН ХАМГААЛАЛТ

Amway-н Нийлүүлэгчид оюуны өмчийн эрхийг зохицуулсан холбогдох бүх хуулийг хүндэтгэх, дагаж мөрдөх, оюуны өмчийг зөвшөөрөлгүй задруулах болон ашиглахаас сэргийлэх, мөн Amway-н оюуны өмчийг ашиглахтай холбоотойгоор тавьдаг шаардлагуудыг дагаж мөрдөх үүрэгтэй. Технологи болон ноу-хауг ашиглахдаа Нийлүүлэгчид нь Amway-н болон бусад хүмүүсийн оюуны өмчийн эрхийг зөрчихгүй байх ёстой бөгөөд зөвхөн хууль ёсны дагуу олж авсан, лицензтэй мэдээллийн технологи, програм хангамжийг л ашиглана.

ХИЙМЭЛ ОЮУН УХААН АШИГЛАХ ДҮРЭМ

Amway компани үйл ажиллагааныхаа бүхий л чиглэлд болон өргөтгөсөн ханган нийлүүлэлтийн сүлжээндээ ч хиймэл оюун ухааны технологийг ёс зүйтэй, аюулгүй, нууцлалыг өндөр хамгаалалттай, хууль эрх зүйн шаардлага хангасан байдлаар ашиглах зарчмыг баримталдаг. Хэдийгээр хиймэл оюуны технологи нь үр ашиг нэмэгдүүлэх, инновацийг дэмжих, шийдвэр гаргах үйл явцыг сайжруулах зэрэг өргөн боломжийг олгодог ч түүний хэрэглээ нь өгөгдлийн хамгаалалт, ил тод байдал, хариуцлага, алгоритмын шударга байдалтай холбоотой янз бүрийн эрсдэлүүдийг дагуулж болзошгүй тул зохих ёсны хяналт шаарддаг. Иймд Amway-ийн нэрийн өмнөөс хиймэл оюун ухааны системийг ашигладаг эсвэл Amway-ийн ашигладаг болон үйл ажиллагаатай нь холбоотой бүтээгдэхүүн, үйлчилгээ, платформд хиймэл оюуны технологийг нэвтрүүлдэг Нийлүүлэгчид нь хиймэл оюуны зохицуулалтын холбогдох бүх хууль тогтоомж, норматив шаардлагыг дагаж мөрдөх үүрэгтэй. Хиймэл оюун ухааны системийг хүний зохих хяналттайгаар, шударга ёсны дагуу ил тод боловсруулан нэвтрүүлэх ёстой. Хиймэл оюун ухааны технологийг хариуцлагатайгаар ашиглах нь Нийлүүлэгчийн мэдээлэл өгөгдлийг хамгаалах, хүний эрхийг дээдлэх, шударга бизнесийн зарчмаар үйл ажиллагаа явуулах нийтлэг үүргийн салшгүй хэсэг гэж үзнэ.



ХҮНИЙ ЭРХ БА ХӨДӨЛМӨРИЙН ХАРИЛЦАА

Нийлүүлэгчийн бүх ажилчид шударга, ёс зүйтэй нөхцөлд ажиллах эрхтэй. Нийлүүлэгчид нь ажилчдадаа хүндэтгэлтэй хандах, тэдний нэр хүндийг дээдлэх тал дээр хүний эрхийн хамгийн өндөр стандартуудыг дагаж мөрдөх үүрэгтэй.

ХӨДӨЛМӨРИЙН ХУУЛЬ ТОГТООМЖИЙГ САХИХ

Нийлүүлэгчид хөдөлмөрийн харилцааг зохицуулсан холбогдох бүх хууль тогтоомж, зохицуулалтын шаардлага, гэрээний үүргийг нийт ажилтнуудынхаа хувьд мөрдөх ёстой. Үүнд хөдөлмөрийн гэрээтэй ажилтнууд, дадлагажигчид, түр ажилтнууд болон ажил гүйцэтгэхэд татан оролцуулсан бусад хүмүүс хамрагдана. Нийлүүлэгчид ажилчдадаа хууль тогтоомж, зохицуулалтын акт эсвэл гэрээгээр олгогдсон нийгмийн баталгаа, хөнгөлөлтүүдийг хангах үүрэгтэй. Үүнд эмнэлгийн үйлчилгээ, нийгмийн даатгал болон бусад зайлшгүй төлбөрүүд орно. Мөн ажилтнуудын хөдөлмөр эрхлэлтийн хууль ёсны байр суурийг нь хангах ёстой. Нийлүүлэгчдийн ажилтнууд Amway-н объект, байгууламж дээр ажлаа хийж гүйцэтгэхдээ Amway-н хөдөлмөр хамгааллын болон аюулгүй байдлын стандарт, шаардлагуудыг дагаж мөрдөх үүрэгтэй.

ЯЛГАВАРЛАН ГАДУУРХАЛТ, ХҮЧИРХИЙЛЭЛ, ДАРАМТ ШАХАЛТЫГ ХОРИГЛОХ

Нийлүүлэгчид нь арьс өнгө, үндэс угсаа, нас, хүйс, шашин шүтлэг болон одоо мөрдөгдөж буй холбогдох хуулиудаар хамгаалагдсан өөр бусад шинж тэмдгээр нь хүмүүсийг ажилд авах, цалин олгох, албан тушаал дэвшүүлэх, ажлаас халах, эсвэл хөдөлмөрийн харилцааны бусад чиглэлүүдээр ялгаварлан гадуурхахыг хатуу хориглоно. Нийлүүлэгчид нь ажилчидтайгаа хүндэтгэлтэй, зөв харьцах үүрэгтэй бөгөөд үг хэлээр доромжлох, бие махбод, сэтгэл зүйгээр болон бусад арга замаар хүчирхийлэх, дарамт шахалт үзүүлэх, сүрдүүлэх, заналхийлэх зэргийг хатуу хориглоно.

ХҮҮХДИЙН ХӨДӨЛМӨР

Хүүхдийн хөдөлмөрийг ашиглахыг хатуу хориглоно. “Хүүхэд” гэдэгт 16 нас хүрээгүй, эсвэл заавал эзэмших ёстой боловсролоо дуусгаагүй, мөн холбогдох хууль тогтоомжоор тогтоосон хөдөлмөр эрхлэх доод насанд (хэдэн настай байгаагаас нь хамаарна) хүрээгүй аливаа хүнийг ойлгоно.

Нийлүүлэгчид насанд хүрээгүй хүмүүсийн хөдөлмөр эрхлэлтийг зохицуулсан холбогдох бүх хууль тогтоом, дүрэм журмыг дагаж мөрдөх үүрэгтэй.

АЛБАДАН ХӨДӨЛМӨР

Хөдөлмөр зөвхөн сайн дурын үндсэн дээр хийгдэх ёстой. Нийлүүлэгчид үйл ажиллагаа болон ханган нийлүүлэх сүлжээндээ хүмүүсийг өр шир, амьдралынх нь бэрхшээл дээр дөрөөлөн албадан хөдөлмөр эрхлүүлэх, түүнчлэн боолчлол эсвэл хүний наймаа гарахаас урьдчилан сэргийлж, тэдгээрийг хатуу хориглох үүрэгтэй.

АЖЛЫН ЦАГ БА ШУДАРГА ЦАЛИН ХӨЛС


Нийлүүлэгчид цалин хөлс болон ажлын цагийн тал дээр холбогдох бүх хууль эрх зүйн шаардлагуудыг, тэр дундаа хөдөлмөрийн хөлсний доод хэмжээ, тэтгэмж тэтгэлэг, ажлын цаг, амралтын цаг болон илүү цагийн хөлстэй холбоотой норм, журмыг дагаж мөрдөх шаардлагатай. Нийлүүлэгчид ажлын цагийн дээд хязгаарыг хэтрүүлэхгүй байх, мөн хөдөлмөрийн аюулгүй байдлын шаардлагыг хангасан ажиллах нөхцөлийг бүрдүүлж өгөх үүрэгтэй.

Ажилчдын, тэр дундаа гэрээгээр ажиллагсдын цалин хөлс нь хуулиар тогтоосон доод хэмжээнээс бага байж болохгүй. Нийлүүлэгчид ажилчдадаа цалингийн бүтэц болон цалин олгох хуваарийн талаар урьдчилан мэдэгдэж, цалин хөлсийг цаг тухайд нь төлдөг байх ёстой. Нийлүүлэгчид нь ажилчдадаа хууль, журмын дагуу чөлөө өгөх, амралтын өдрүүд болон ээлжийн амралтаар хангах үүрэгтэй бөгөөд үүнд албан ёсны баярын өдрүүд ч гэсэн хамаатай болно.

НЭГДЭН НИЙЛЭХ ЭРХ ЧӨЛӨӨ БА ГОМДОЛ МЭДҮҮЛЭХ МЕХАНИЗМ

Нийлүүлэгчид ажилтнуудын хууль ёсоор байгуулагдсан аливаа холбоо, нэгдэлд нэгдэх эсвэл нэгдэхгүй байх эрхийг зохицуулсан холбогдох бүх хууль тогтоомжийг, мөн олон улсын хөдөлмөрийн стандартыг мөрдөх үүрэгтэй. Энэ эрхийг хэрэгжүүлэх явцад ажилтнууд хариу арга хэмжээ авах, дарамт шахалт үзүүлэх, мөрдөн мөшгих зэрэг аливаа сөрөг нөлөөнд өртөх ёсгүй.

Гомдол гаргагч нь сөрөг үр дагавар үүснэ гэж айж эмээлгүйгээр гомдлоо гарган хянуулж, шийдвэрлүүлдэг шударга, нууцлал өндөртэй, шаардлагатай бол хүний нэрийг нууцалдаг системийг нэвтрүүлэн дэмжин ажиллах үүргийг Нийлүүлэгчид хүлээнэ. Энэхүү систем нь бүх ажилчдад ил тод, ойлгомжтой бөгөөд хүртээмжтэй байх ёстой. Хууль тогтоомжид заасан тохиолдолд зөрчлийн талаар мэдээлсэн хүмүүсийг Нийлүүлэгч нь зохих ёсоор хамгаалах үүрэгтэй.



ХӨДӨЛМӨР ХАМГААЛАЛ БА АЖЛЫН БАЙРНЫ АЮУЛГҮЙ БАЙДАЛ

Ажлын аюулгүй, эрүүл орчин нь гэмтэл бэртэл, мэргэжлээс шалтгаалсан өвчний тохиолдлуудыг бууруулахаас гадна бүтээгдэхүүн, үйлчилгээний чанар, үйлдвэрлэлийн тогтвортой байдал, ажилчдын тогтвор суурьшил болон хамт олны уур амьсгалыг сайжруулдаг. Amway-н Нийлүүлэгчид хөдөлмөр хамгаалал болон аюулгүй байдлын эрсдэлийг цаг тухайд нь олж илрүүлэн, үр дүнтэй бууруулахад ажилчдын оролцоо болон тэдэнд зориулагдсан курс, сургалтууд зайлшгүй шаардлагатай гэдгийг хүлээн зөвшөөрөх ёстой.

ХӨДӨЛМӨР ХАМГААЛАЛ, ҮЙЛДВЭРЛЭЛИЙН АЮУЛГҮЙ БАЙДАЛ БОЛОН ЭРСДЛЭЭС УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ

Нийлүүлэгчид нь ажилчдынхаа ажлын байрыг хөдөлмөр хамгаалал, эрүүл мэндийн болон аюулгүй байдлын орон нутгийн болон улсын холбогдох хуулийн шаардлагуудад нийцүүлэн зохион байгуулах үүрэгтэй. Ажиллах орчинд аюул, осол үүсгэгч хүчин зүйлүүд байх ёсгүй бөгөөд үүнд химийн бодистой зохих ёсоор харьцах, инженерийн болон үйлдвэрийн тоног төхөөрөмжийн аюулгүй ажиллагааг хамгаалалтын хэрэгслүүдийн тусламжтайгаар хянах, мөн цахилгааны эх үүсвэрүүдийг тусгаарлах, ажилчдыг сайн нөхцөлд хадгалсан хувийн хамгаалах хэрэгслүүдээр хангах, тэдгээрийг хэрхэн ашиглах талаар заавал дагаж мөрдүүлэх заавар зөвлөгөөг өгөх, сургалт явуулах зэрэг ажлууд багтана. Нийлүүлэгчид эрсдэлийн үнэлгээ, сургалт, аудит, үзлэг, аюулгүй ажиллагаа, онцгой байдлын хариу арга хэмжээг авах журам зэрэг удирдлагын үр дүнтэй системээр дамжуулан хөдөлмөрийн эрүүл мэнд, аюулгүй байдлын эрсдэлийг тодорхойлох, үнэлэх, хянах үүргийг хүлээнэ.

ХООЛ, БАЙР, ЭРҮҮЛ АХУЙН НӨХЦЛҮҮД

Нийлүүлэгчид ажилчдадаа цэвэрхэн ариун цэврийн өрөө, аюулгүй ундны ус, түүнчлэн хоол хийх, хоол хүнс хадгалах болон хооллоход зориулагдсан цэвэрхэн өрөө тасалгааг гаргаж өгөх зэргээр ариун цэврийн зохих ёсны нөхцлийг хангасан байх ёстой. Нийлүүлэгч ажилчдыг орон сууцаар хангаж байгаа тохиолдолд тухайн байр нь амьдрахад тохиромжтой, холбогдох норм, хэм хэмжээний шаардлагуудыг хангасан байх ёстой.

ОНЦГОЙ БАЙДАЛ ҮҮСЭХЭЭС УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ, БЭЛЭН БАЙДАЛ ХАНГАХ, ХЭРЭВ ҮҮССЭН ТОХИОЛДОЛД ХАРИУ АРГА ХЭМЖЭЭГ АВАХ

Нийлүүлэгчид үүсч болзошгүй онцгой байдлын нөхцөл байдлыг олж илрүүлэн, түүнд үнэлэлт, дүгнэлт өгөх үүрэгтэй. Илрүүлсэн нөхцөл болгон дээр Нийлүүлэгчид хүний амь нас, эрүүл мэнд, хүрээлэн буй орчин болон эд хөрөнгөд учирч болзошгүй аюул, хохирлыг багасгахад чиглэгдсэн хариу арга хэмжээний төлөвлөгөө, журмыг боловсруулан хэрэгжүүлэх, мөн тийм төлөвлөгөөг дэмжин ажиллах шаардлагатай.

ТАЙЛАНГИЙН НАЙДВАРТАЙ БАЙДАЛ БА ШАЛГАЛТ ЯВУУЛАХ ЭРХ

Нийлүүлэгчид нь шаардсан өгөгдөл, мэдээллүүдийг ямар нэг ноцтой үндэслэл байхгүй бол удааж хойшлуулалгүйгээр үнэн зөвөөр нь өгөх үүрэгтэй, учир нь ийм мэдээллүүд нь Amway-н үйл ажиллагаа, хууль тогтоомжийн хэрэгжилт, санхүүгийн тайлан болон компанийн засаглалд чухал ач холбогдолтой байдаг. Нийлүүлэгчид Amway-тэй харилцахтай холбоотой баримт бичгүүдийг хөтлөх, хадгалах, мөн холбогдох хүсэлт, шаардлагын дагуу Amway-д хүлээлгэн өгөх үүргийг хүлээнэ. Энэхүү Дүрмээр тогтоосон Стандартуудыг дагаж мөрдөх үүднээс Нийлүүлэгчид нь үзлэг шалгалтаар яваа Amway-н төлөөлөгчдийг, итгэмжлэгдсэн болон эрх бүхий төлөөлөгчдийг эсвэл гуравдагч, хараат бус байгууллагуудын хүмүүсийг өөрсдийн объектуудад нэвтрүүлэх үүрэгтэй болно.

ОСЛЫН ҮЕИЙН УДИРДЛАГА

Нийлүүлэгчид нь ажилчдад хөдөлмөр хамгаалал болон аюулгүй байдалтай холбоотой ослын талаар, түүний дотор аюултай нөхцөл байдал үүсэж болзошгүй байгаа талаар мэдээлэх боломжийг олгодогдоос гадна ийм мэдээг шалгах, бүртгэх, хянахад тусалдаг системүүдийг нэвтрүүлэх үүрэгтэй. Нийлүүлэгчид эрсдэлийг бууруулах, гэмтэж бэртсэн ажилчдад шаардлагатай эмнэлгийн тусламж үзүүлэх, ажилдаа аюулгүйгээр эргэн ороход нь туслах шаардлагатай арга хэмжээнүүдийг авна.

БАЙГАЛЬ ОРЧНЫ ХАМГААЛАЛТ

Amway компанийн Нийлүүлэгчид байгаль орчныг хамгаалахтай холбоотойгоор хүлээсэн үүргээ зохих ёсоор нь биелүүлэх ёстой. Үйлдвэрлэлийн үйл ажиллагаа явуулахдаа Нийлүүлэгчид хүн амын амь нас, эрүүл мэндийг нь хамгаалахын зэрэгцээ хүмүүст, байгаль экологид болон байгалийн нөөцөд үзүүлэх сөрөг нөлөөллийг багасгах үүрэгтэй.

ТУСГАЙ ЗӨВШӨӨРӨЛ БА ТАЙЛАН

Нийлүүлэгчид нь байгаль орчныг хамгаалахтай холбоотой орон нутгийн болон улсын хууль тогтоомж, эрх зүйн актуудыг дагаж мөрдөх шаардлагатай. Нийлүүлэгчид шаардлагатай бүх байгаль орчны зөвшөөрөл, зөвшилцөл, бүртгэлийг авч, хүчинтэй байлгаж, хугацаанд нь сунгах, тогтоосон ашиглалтын болон тайлагналын шаардлагыг биелүүлэх ёстойгоос гадна Amway компанийн холбогдох хүсэлтийн дагуу хаягдлын талаарх болон байгаль орчинд үзүүлэх нөлөөллийн талаарх мэдээллийг гаргаж өгөх үүрэгтэй.

БОХИРДЛООС СЭРГИЙЛЭХ БА НӨӨЦИЙН ХЭРЭГЛЭЭГ БУУРУУЛАХ

Нийлүүлэгчид байгалийн нөөцийн хэрэглээг, тэр дундаа ус, эрчим хүчний хэрэглээг бууруулах эсвэл боломжтой бол бүрэн хасахыг эрмэлзэх ёстой. Мөн хог хаягдал үүсэх явдлыг бууруулах, арилгах арга хэмжээ авах шаардлагатай. Эдгээр арга хэмжээнүүдэд нөөцийг хэмнэх, дахин боловсруулах, материалыг дахин ашиглах, орлуулах, үйлдвэрлэл болон үйл ажиллагааны процессыг сайжруулах зэрэг нь орно.

АЮУЛТАЙ БОДИСУУД

Нийлүүлэгчид нь химийн бодис болон бусад аюултай байж болзошгүй материалуудыг олж илрүүлэн, зохих ёсоор нь хянаж, тэдгээрийг аюулгүй тээвэрлэх, хадгалах, ашиглах, боловсруулах, устгах үүргийг хүлээнэ.

БОХИР УС БА ХАТУУ ХАЯГДЛУУД

Нийлүүлэгчид нь аюултай ангилалд багтахгүй хатуу хог хаягдлыг олж илрүүлэх, хянах, багасгах, хариуцлагатайгаар удирдахад чиглэгдсэн системтэй хандлагыг хэрэгжүүлэх үүрэгтэй. Нийлүүлэгчид нь бохир ус үүсэх явдлыг бууруулах арга хэмжээг авна. Үйлдвэрлэлийн үйл ажиллагааны явцад үүссэн бүх бохир усыг зайлуулах эсвэл зайлуулахаасаа өмнө холбогдох хууль тогтоомжийн шаардлагын дагуу зохих ёсоор ангилж, хянаж, цэвэрлэсэн байх ёстой.

Нийлүүлэгчид нь бохир ус цэвэршүүлэх системийн үйл ажиллагааны үр ашгийг тогтмол хянаж байх үүрэгтэй.

АГААРЫН БОХИРДОЛ

Нийлүүлэгчид өөрсдийнх нь үйл ажиллагаанаас үүдэлтэй дэгдэмхий органик химийн бодис, аэрозоль, идэмхий бодис, тоосонцор, озоны давхаргыг задалдаг химийн бодис, шаталтын дайвар бүтээгдэхүүн зэрэг агаарт ялгарах хорт бодисыг тодорхойлж (тодорхойлно гэдэгт ийм төрлийн хаягдлыг таниж илрүүлэх, тоо хэмжээг тогтоох, ийм хаягдлын шинж чанарыг нь ойлгох зэрэг нь багтана), хаяхаасаа өмнө холбогдох хууль тогтоомж, журмын дагуу тогтмол хянаж, шүүж цэвэрлэнэ. Нийлүүлэгчид атмосфер дахь ялгарлыг хянах системийнхээ үйл ажиллагааны үр нөлөөг тогтмол хянаж үнэлгээ хийх үүрэгтэй.

МАТЕРИАЛТАЙ ХОЛБООТОЙ ХЯЗГААРЛАЛТУУД

Нийлүүлэгчид бүтээгдэхүүн болон үйлдвэрлэлийн үйл явцад зарим бодисыг ашиглахыг хориглох буюу хязгаарлахтай холбоотой холбогдох бүх хууль тогтоомжийг мөрдөх үүрэгтэй. Үүнд шошгололт, дахин боловсруулалт, устгал зэрэгтэй холбоотой шаардлагууд ч ч гэсэн хамаатай болно.

ГАЗАР ЭЗЭМШИХ ЭРХИЙГ ХҮНДЛЭХ

Нийлүүлэгчид нь гуравдагч этгээдүүдийн үл хөдлөх өмчийн эрх, оюуны өмчийн эрх болон бусад эрхийг дээдлэн хүндэтгэж, өөрсдийн үйл ажиллагаагаа явуулдаг орон нутгийн нийгэмлэгүүдийнхээ тогтвортой хөгжилд дэмжлэг үзүүлэх үүрэгтэй.

ХАРИУЦЛАГАТАЙ ЭХ СУРВАЛЖААС АВСАН МАТЕРИАЛУУД

Нийлүүлэгчид түүхий эдийн гарал үүслийн ил тод байдал, мөрдөн хянах боломжийг хангахад чиглэсэн Amway-ийн хүчин чармайлтад бүрэн дэмжлэг үзүүлж, ханган нийлүүлэлтийн бүх үе шатын талаар үнэн зөв, бүрэн мэдээлэл өгөх үүрэгтэй.

ТҮҮХИЙ ЭДЭД ХАРИУЦЛАГАТАЙ ХАНДАХ

Amway компани чанарын шаардлага хангасан түүхий эд болон бүтээгдэхүүнийг нийлүүлдэг Нийлүүлэгчидтэй хамтран ажилладаг. Нийлүүлэгчид холбогдох бүх хууль тогтоомж, дүрэм журмуудыг, тухайлбал Биологийн төрөл зүйлийн тухай конвенцын заалтуудыг дагаж мөрдөх үүрэгтэй. Нийлүүлэгчид Amway-н чанар, аюулгүй байдлын шаардлага болон техникийн үзүүлэлтүүдэд нийцүүлэх, чанарыг тасралтгүй сайжруулах болон шаардлага хангаагүй материалуудыг нийлүүлэхээс урьдчилан сэргийлэх арга хэмжээнүүдийг авна. Түүхий эдийг хариуцлагатай бөгөөд тогтвортой эх үүсвэрүүдээс худалдан авч, байгаль орчны эрсдлийг хамгийн бага түвшинд байлгах ёстой. Нийлүүлэгчид түүхий эдийн гарал үүсэл нь хүрээлэн буй орчин, нутгийн уугуул иргэд болон орон нутгийн нийгэмлэгүүдэд аюул учруулахгүй гэдгийг нотлох баримт бичгийг бүрдүүлэн өгөх үүрэгтэй.

МАТЕРИАЛ, ҮЙЛЧИЛГЭЭ БА ТЭМДЭГЛЭГЭЭ/ШОШГОЛОЛТ

Amway компани нь бүх бүтээгдэхүүн, түүхий эд болон бүтээгдэхүүнд хамааралтай хэсгүүддээ (жишээ нь: шошгонд) чанарын болон аюулгүй байдлын зохих хэмжээний туршилтын үзүүлэлтүүдийг тодорхойлон боловсруулдаг. Зөв үзүүлэлтүүдийг оруулсан эсэхийг баталгаажуулахын тулд олон салбарын мэргэжилтнүүдээс бүрдсэн багийнхан эдгээр техникийн үзүүлэлтүүдийг хянан баталдаг. Эдгээр техникийн үзүүлэлтүүдийг дагаж мөрдөж байгааг баталгаажуулахын тулд Нийлүүлэгчид материалуудаа туршиж үзэх шаардлагатай бөгөөд эдгээр материалууд нь Amway-н шаардлагыг хангаж байгааг нотолсон шинжилгээний гэрчилгээ эсвэл тохирлын гэрчилгээг өгөх шаардлагатай. Amway компани бүх бүтээгдэхүүн, түүхий эд болон бүрэлдэхүүн хэсгүүдээ хэрэглэгчдэд хүргэхээс өмнө заавал туршиж, баталгаажуулдаг.

ХҮНСНИЙ БҮТЭЭГДЭХҮҮНИЙ АЮУЛГҮЙ БАЙДАЛ БА ЧАНАР

Amway нь Дэлхийн хэмжээний компанийн хувьд үйл ажиллагаагаа явуулж буй улс орон бүрийн зах зээл болгоныхоо дүрэм журам, норм нормативын хэм хэмжээг дагаж мөрддөг. Нийлүүлэгчид үйл ажиллагаанд хамаарах бүх хууль тогтоомж, норм нормативын хэм хэмжээ, мөн түүнчлэн чанар, аюулгүй байдлын холбогдох стандартыг мөрдөх үүрэгтэй. Хүнсний орц найрлага эсвэл хүнсний бүтээгдэхүүнтэй шууд харьцах материалуудыг нийлүүлдэг Нийлүүлэгчид хүнсний аюулгүй байдлын талаарх холбогдох бүх шаардлагуудыг дагаж мөрдөх үүрэгтэй.

АМЬТАД ДЭЭР ТУРШИЛТ ЯВУУЛАХ БОЛОН АМЬТДЫГ ХАМГААЛАХ

Amway компани түүхий эд, бүрэлдэхүүн хэсгүүд болон бэлэн бүтээгдэхүүнийхээ аль алиныг нь амьтад дээр туршдаггүй. Amway өөрийн комданниас гадуур авсан орц найрлага, материалууддаа стандартын шаардлагыг хангаж, мөн амьтад дээр туршигдаагүй гэсэн баталгааг өгдөг.

Гэсэн хэдий ч зарим тохиолдолд улсаас эсвэл зохицуулагч байгууллагуудын зүгээс бэлэн бүтээгдэхүүнийг амьтад дээр туршихыг шаардах тохиолдол бий. Ийм үед Нийлүүлэгчид маань боломжтой бол орлуулах ижил төстэй туршилтын өөр аргыг ашиглаж, тэр аргаа амьтад дээр турших шаардлагыг эсэргүүцэн, гарсан шийдвэрийг өөрчлөхөд нөлөөлөх зорилгоор эрх мэдэлтэй байгууллагуудад танилцуулах үүрэгтэй. Амьтны туршилтыг зөвхөн хууль, зохицуулалтын зайлшгүй шаардлагатай тохиолдолд зөвшөөрөх бөгөөд ийм туршилтыг Amway бус, харин эрх бүхий төрийн байгууллагаар зөвшөөрөгдсөн бие даасан, магадлан итгэмжлэгдсэн лаборатори гүйцэтгэнэ. Нийлүүлэгчид амьтад дээр туршилт хийхгүй гэсэн Amway-н байр суурийг барьж, ийм төрлийн туршилтаас татгалзах хатуу зарчмуудыг дагаж мөрдөх үүрэгтэй.



ТӨГСГӨЛИЙН ЗААЛТУУД

Нийлүүлэгчид тогтоосон Стандартын хэрэгжилтийг биелүүлэхэд хангалттай нөөцийг хуваарилах замаар энэхүү Дүрэмд заасан зарчмуудыг дагаж мөрдөнө гэдгээ батлан харуулна. Нийлүүлэгчид Amway-н нийлүүлэгчийн ёс зүйн Дүрэмд хамрагдах эрсдэлийг тодорхойлох, үнэлэх, удирдах механизмыг хэрэгжүүлэх үүрэгтэй.

Amway-ийн хүсэлтээр нийлүүлэгчид эдгээр Стандартуудыг мөрдөж байгаа гэдгээ өөрсдөө баталгаажуулж, Amway компанид хууль ёсны үүргээ хэрэгжүүлэхэд шаардлагатай нөхцөлөө бүрдүүлсэн гэдгээ харуулсан тайлан болон бусад мэдээллийг гаргаж өгөх үүрэгтэй.

АШИГ СОНИРХОЛЫН ЗӨРЧИЛ БОЛОН ДҮРМИЙН ЗӨРЧЛИЙГ МЭДЭЭЛЛЭХ ЖУРАМ

Нийлүүлэгчид ашиг сонирхолын зөрчилтэй холбоотой үүсч болзошгүй болон/эсвэл бодит зөрчлийн талаарх мэдээллийг дараах аргаар

- (1) Amway-н ёс зүйн мэдээллүүдийг хүлээн авах программыг <https://amway.ethicspoint.com> хаягаар;
 - (2) Alticor Inc., Chief Compliance Officer, Mail Code 78-2M, 7575 Fulton Street East, Ada, Michigan, United States of America 49355 хаягаар бичгээр мэдэгдэх;
 - (3) ChiefComplianceOfficer@amway.com цахим шуудан руу бичих;
 - (4) Amway-н менежер эсвэл түүнээс дээш албан тушаалтай ажилтантай шууд холбоо барих зэрэг замаар холбогдож мэдээлэх боломжтой.
- Нийлүүлэгчид энэхүү Дүрмийн боломжит эсвэл бодит зөрчлийн талаар дээр дурдсан аргуудаар мэдэгдэх, эсвэл Amway компанийн шаардлага хангалтын талаарх мэдээлэл хүлээн авах Глобал хөтөлбөрөөр дамжуулан нэрээ нууцлан мэдээлэх эрхтэй. <https://amway.ethicspoint.com>

ДҮРЭМ ЗӨРЧИХ БОЛОН АУДИТ ЯВУУЛАХ ЭРХТЭЙ ХОЛБООТОЙ ЗААЛТ

Amway компанитай харилцаанд орж буй аливаа Нийлүүлэгч нь эдгээр Стандартын заалтанд оруулсан шаардлагыг хангаж буй эсэхийг баталгаажуулах зорилгоор Amway аудит хийх эрхтэйг хүлээн зөвшөөрнө.

Нийлүүлэгчид Amway өөрийн үзэмжээр аудит хийх, үүнд Нийлүүлэгчийн объектод шалгалт хийх болон (эсвэл) баримт бичгийн аудит явуулах замаар Кодексийн шаардлагыг хангаж буй эсэхийг баталгаажуулах эрхтэй гэдгийг зөвшөөрнө. Amway нь аудит заавал явуулах үүрэг хүлээхгүй. Amway-н Нийлүүлэгчийн ёс зүйн дүрмийг зөрчих нь холбогдох гэрээний нөхцлөөс хамааран Amway болон Нийлүүлэгч хоорондын гэрээт үүргийг ноцтойгоор зөрчсөнд тооцогдоно.

ДАРАМТ ШАХАЛТ ҮЗҮҮЛЭХИЙГ ҮЛ ТЭВЧИХ БОДЛОГО

Нийлүүлэгчид Amway-н дотоод бодлогыг зөрчсөн талаар сайн дураараа мэдээлсэн, үүсч болзошгүй зөрчлийн талаар санаа зовниж байгаагаа илэрхийлсэн, мөрдөн шалгах ажилд тусалсан эсвэл энэхүү Дүрмийн заалтуудын талаар тодруулга авахыг хүссэн хүмүүст ямар нэгэн хэлбэрээр дарамт шахалт үзүүлэх эсвэл сахилгын арга хэмжээ авах явдлыг гаргахгүй байх үүргийг хүлээнэ.

Amway